“Ази судлалын тэнхим дипломын ажлын II үзлэг зохион байгууллаа”

2026 оны 11 дүгээр сарын 20

Ази судлалын тэнхим 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бакалавр оюутны дипломын ажлын II үзлэгийг амжилттай зохион байгууллаа.



Үзлэгт Ази судлалын тэнхимийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Л.Чойжилмаа, профессор Н.Мэнд, дэд профессор Ц.Эрдэнэзаяа, ахлах багш Ч. Оюунгэрэл, Б.Ундармаа, Р.Бигэрмаа, багш Л. Сарангэрэл, П.Мөнгөнцэцэг, Н.Булганчимэг, Д.Анхтуяа нар оролцож, оюутнуудын дипломын ажлын явц, судалгааны үр дүнтэй танилцан, цаашид анхаарах асуудал болон судалгааны ажлын чанарыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, санал зөвлөмж өглөө.





Энэ удаагийн үзлэгт Ази судлалын тэнхимийн бакалаврын түвшний нийт 8 оюутан судалгааны ажлаа танилцуулж, эрдэмтэн багш нараас санал, зөвлөгөө авлаа.




Дипломын ажлын үзлэг нь оюутнуудын судалгааны ажлын явц, үр дүнг үнэлэх, судалгааны ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, судалгааны арга зүйн мэдлэг, чадварыг хөгжүүлэх, цаашдын судалгааны чиглэл, зорилтыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.





Дипломын ажлын II үзлэг нь оюутнуудын судалгааны ажлыг үе шаттайгаар хөгжүүлэх, эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг сайжруулах, мэргэжлийн багш нарын удирдлага, зөвлөмжийн хүрээнд судалгааны ажлаа улам боловсронгуй болгох боломжийг бүрдүүлж байгаагаараа онцлог юм.





Судалгааны ажлаа танилцуулсан оюутнууддаа эрдэм судлалын ажилд нь өндөр амжилт хүсье. Мөн үзлэгт оролцож, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн эрдэмтэн багш нартаа ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

